

## ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**ЗСБНХУ-ЫН 60 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ**

ЗСБНХУ- байгуулагдсаны 60 жилийн ойд зориулан БНМАУ-ын ШУА-ийн нийгмийн ухааны хүрээлэнгүүдийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хурал 1982 оны 12-р сарын 20-нд Улсын нийтийн номын сангийн хурлын танхимд болов.

Тус бага хурлыг ШУА-ын дэд ерөнхийлөгч академич Ш.Нацагдорж нээж үг хэлэв.

Эрдэм шинжилгээний энэ бага хуралд «ЗСБНХУ-д үндэстний асуудлыг шийдвэрлэсэн явдал дорно дахины ард түмний хувь заяанд нөлөөлсөн нь» гэсэн илтгэлийг Дорнодахины судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч, дэд эрдэмтэн Б. Батболд тавив. Энэ илтгэлд Дундад Ази, Алс Дорнод, Умард хязгаарын олон ард түмэн агуу их ЗСБНХУ-ын олон үндэстний өнөр гэр бүлд багтан орж, хөгжлийн капиталист шатыг алгасан хөгжингүй социалист нийгэм байгуулсан туршлагын олон улсын ач холбогдлыг дурдаад энэ үйл явдал, тухайлбал нийт Ази, Алс Дорнод, Дорнодахины ард түмний хувь заяанд гүн гүнзгий хувьсгалжуулагч нөлөө үзүүлж улмаар гагцхүү социалист нийгэмд үндэстний асуудлыг зөв шийдвэрлэх бололцоотойг ЗСБНХУ-ын жишээн дээр тодорхой баримтаар нотлон харуулав. Орос оронд социалист хувьсгал ялж, ЗСБНХУ байгуулагдсан нь Ази, Алс Дорнодын орнуудыг эрх чөлөөний хөдөлгөөний хүчит өрнөлтөд уриалан дуудсан юм. Аугаа их Октябрийн шууд нөлөөгөөр Монголд 1921 онд ялсан Ардын хувьсгал нь монголын ард түмэнд эрх чөлөө, тусгаар тогтнолыг авчирч үндэстний асуудлыг шийдвэрлэх Лениний агуу их үзэл санааг тусгаар тогтносон бүрэн эрхт улсын хэмжээнд хэрэгжүүлсэн юм гэдгийг илтгэгч цохон тэмдэглэв.

Доктор Н. Сэд-Оджав «Монгол, зөвлөлтийн түүхчдийн хамтын ажиллагаа» гэсэн илтгэлдээ монгол, зөвлөлтийн эрдэмтдийн нягт хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд амжилттай өргөжин гүнзгийрч монголын түүх, монгол-зөвлөлтийн харилцааны талаар олон талын судалгаа шинжилгээний ажил явуулж байгааг тэмдэглэв. Хамтын ийм ажиллагааны үр дүнд монгол, зөвлөлтийн эрдэмтдийн хамтын бүтээл «БНМАУ-ын түүх» (нэгэн боть)-ийн шинэ хэвлэл, «Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх» зэрэг дорвитой бүтээлүүд туур-вижээ.

Мөн монгол, зөвлөлтийн хамтарсан түүх, соёлын экспедиц улам өргөжиж Монголын түүхэнд холбогдолтой шинэ шинэ олдворуудыг олж байгааг илтгэгч тодорхой баримтаар харуулав.

ШУА-ийн Хэл зохиол судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ж. Энэбиш «Монголын орчин үеийн хөгжмийн урлагт Б. Смирновын оруулсан хувь нэмэр» гэсэн илтгэлдээ манай оронд үндэстний хэлбэртэй, социалист агуулгатай мэргэжлийн хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд ЗХУ-аас олон арван хөгжмийн зүтгэлтнүүд уригдан ирж, өө-

рийн мэдлэг, авьяас билэг, хүч хөдөлмөрөө зориулж ах дүүгийн интернационалч тусламжийг үзүүлсэн юм гэдгийг манай оронд уригдан ирж ажиллаж байсан хөгжим судлаач, зохиолч, сурган хүмүүжүүлэгч Б. Смирновын олон талт үйл ажиллагаагаар тодорхой харуулжээ.

Ж. Энэбиш илтгэлдээ «өнөөгийн монголын хөгжмийн соёлын салбарт олсон ололт амжилт бүхэд нь, ЗХУ-ын өндөр мэргэжилтэй боловсон хүчний ах дүүгийн тусламжтай салшгүй холбоотой юм» гэж онцлон тэмдэглэв.

Эрдэм шинжилгээний энэ бага хуралд философийн ухааны дэд эрдэмтэн Д. Дашпүрэв, эрдэм шинжилгээний ажилтан А. Жамбал нар «БНМАУ-д социалист аж төрөх ёс төлөвшин хөгжихөд зөвлөлт аж төрөх ёсны үлгэр дууриал», хэлбичгийн ухааны дэд эрдэмтэн Ч. Дагвадорж «Зөвлөлтийн хүний дүр монголын утга зохиолд» хууль зүйн ухааны дэд эрдэмтэн Т. Сэнгэдорж «БНМАУ дахь социалист ардчиллын хөгжилт», эрдэм шинжилгээний ажилтан Ч. Дашдаваа «Соёлын сэтгэл харамгүй тусламж» гэсэн сонирхолтой илтгэлүүдийг тавилаа.

Тус бага хуралд ЗСБНХУ-аас БНМАУ-д суугаа Элчин сайдын Яамны II нарийн бичгийн дарга, монголч эрдэмтэн В. В. Грайворонский оролцож үг хэлэв.

**Б. Сэржав**